



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 25 өдөр

Дугаар А/169

Улаанбаатар хот

Боловсролын магадлан итгэмжлэх
үндэсний Зөвлөлийн “Удирдах зөвлөл”-ийн
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.3, 26.4, дэх заалт, Засгийн газрын 2018 оны 281 дүгээр тогтоолоор баталсан : Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагын дүрэм”-ийн 2.1.8 дахь хэсэг, “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн дүрэм”-ийн 4.2, 4.3, 4.4, 4.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн “Удирдах зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн хавсралтаар баталсугай.
2. Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Удирдах зөвлөлийн гишүүдийг мэдээллээр хангах, гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны захирал /Ж.Ариунболд/-д үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн “Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/388 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



Ё.БААТАРБИЛЭГ

0300511

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын
сайдын 2019 оны 03 дугаар сарын 25-ны
өдрийн А/169 дугаар тушаалын хавсралт



БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Удирдах зөвлөлийн дарга:	Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн
Дэд дарга:	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн ажлын албаны захирал
Удирдах зөвлөлийн гишүүд:	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Дээд боловсролын асуудал эрхэлсэн нэгжийн дарга
	Хөдөлмөр нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудал эрхэлсэн нэгжийн дарга
	Монголын их, дээд сургуулиудын консорциумын ерөнхийлөгч
	Хувийн их, дээд сургуулиудын холбооны ерөнхийлөгч
	Техникийн болон мэргэжлийн сургуулиудын холбооны тэргүүн
	Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал
	Монголын оюутны холбооны ерөнхийлөгч